



МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙДЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 12 сарын 21 өдөр

Дугаар 205

Улаанбаатар хот

Ажлын хэсэг байгуулах тухай

1.Жендэрийн эрх тэгш байдлыг хангах салбар дундын стратеги төлөвлөгөө (2022-2031)-г хэрэгжүүлэх ажлыг удирдлага, зохион байгуулалтаар хангаж, дүнг 2 жил тутамд танилцуулж байх Ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай:

- | | |
|---------|--|
| Ахлагч | -Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга, Жендэрийн үндэсний хорооны орлогч дарга |
| Гишүүд: | -Эдийн засаг, хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга;
-Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга;
-Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга;
-Байгаль орчин, аялал жуулчлалын яамны Төрийн нарийн бичгийн дарга;
-Боловсрол, шинжлэх ухааны яамны Төрийн нарийн бичгийн дарга;
-Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн дарга;
-Эрүүл мэндийн яамны Төрийн нарийн бичгийн дарга;
-Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Салбарын бодлого зохицуулалтын газрын дарга;
-Удирдлагын академийн захирал;
-Хүний эрхийг хангах үндэсний хорооны Ажлын албаны дарга;
-Монголын үйлдвэрчний эвлэлийн холбооны Хөгжлийн бодлогын газрын дарга (тохиролцсоноор); |

- Монголын үндэсний худалдаа, аж үйлдвэрийн танхимын ерөнхийлөгч (тохиролцсоноор);
- Монголын ажил олгогч эздийн нэгдсэн холбооны Ерөнхий зохицуулалтын газрын дарга (тохиролцсоноор);
- Хэвлэлийн хүрээлэнгийн гүйцэтгэх захирал (тохиролцсоноор);
- Хүчирхийллийн эсрэг үндэсний төвийн захирал (тохиролцсоноор);
- Монфемнет үндэсний сүлжээний зохицуулагч (тохиролцсоноор);
- Жендэрийн үндэсний шинжээчдийн бүлгийн ахлагч;
- Эрдэмтэн судлаачдын бүлгийн ахлагч.

Нарийн бичгийн дарга:

-Жендэрийн үндэсний хорооны нарийн бичгийн дарга бөгөөд Ажлын албаны дарга.

2.Ажлын хэсгийн үйл ажиллагааг зохион байгуулж, шаардлагатай дэмжлэг, туслалцаа үзүүлж ажиллахыг Жендэрийн үндэсний хорооны нарийн бичгийн дарга бөгөөд Ажлын албаны дарга Т.Энхбаярт даалгасугай.



МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД

Л.ОЮУН-ЭРДЭНЭ



УДИРДЛАГЫН АКАДЕМИЙН ЗАХИРЛЫН
ТУШААЛ

2024 оны 02 сарын 02 өдөр

Дугаар А/89

Улаанбаатар хот

Тушаалд өөрчлөлт оруулах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 1.10 дахь заалт, Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 дэх заалт, Монгол Улсын Ерөнхий сайдын 2023 оны 205 дугаар захирамж, Жендэрийн үндэсний хорооны 2023 оны 03 дугаар тогтоол, “Жендэрийн үндэсний хорооны дүрэм”-ийн 4.2.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Удирдлагын академийн захирлын “Салбар дундын багийг байгуулах тухай” 2024 оны А/70 дугаар тушаалын 1. “...Нарийн бичгийн дарга: ...Жендэрийн үндэсний хорооны ТХБ-ын хэлтсийн дарга С.Батцэцэг...” гэснийг 1. “...Гишүүд: ...Жендэрийн үндэсний хорооны ТХБ-ын хэлтсийн дарга С.Батцэцэг...” гэж өөрчилсүгэй.

2. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нарийн бичгийн дарга П.Бямбасүрэнд даалгасугай.

ЗАХИРАЛ



Д.СҮРЭНЧИМЭГ



УДИРДЛАГЫН АКАДЕМИЙН ЗАХИРЛЫН
ТУШААЛ

2024 оны 01 сарын 25 өдөр

Дугаар А/70

Улаанбаатар хот

Салбарын дундын багийг
байгуулах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 1.10 дахь заалт, Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 дэх заалт, Монгол Улсын Ерөнхий сайдын 2023 оны 205 дугаар захирамж, Жендэрийн үндэсний хорооны 2023 оны 03 дугаар тогтоол, “Жендэрийн үндэсний хорооны дүрэм”-ийн 4.2.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Жендэрийн эрх тэгш байдлыг хангах салбар дундын стратеги төлөвлөгөө /2022-2031/-ний “Жендэрийн эрх тэгш байдлыг хангах үндэсний тогтолцоог хөгжүүлнэ” зорилгын хэрэгжилтийг зохион байгуулах салбарын дундын багийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай:

Багийн ахлагч:

Удирдлагын академийн захирал
Д.Сүрэнчимэг

Гишүүд:

Хүний эрхийн үндэсний комиссын
дарга

Төрийн албаны зөвлөлийн гишүүн

Үндэсний статитикийн хорооны
дарга

Засгийн газрын хэрэг эрхлэх
газрын Салбарын бодлого
зохицуулалтын газрын дарга

Сангийн яамны Төрийн нарийн
бичгийн дарга

Хууль зүй дотоод хэргийн яамны
ТНБД-ын албан үүргийг түр орлон
гүйцэтгэгч Л.Нямгэрэл
(зөвшилцсөнөөр)

Цахим хөгжил, харилцаа,
холбооны яамны Төрийн нарийн

бичгийн дарга Б.Батцэцэг
(зөвшилцсөнөөр)

Монголын үндэсний худалдаа, аж
үйлдвэрийн танхимын ерөнхийлөгч
Д.Энхтүвшин (зөвшилцсөнөөр)

Хараат бус судалгааны
хүрээлэнгийн Гүйцэтгэх захирал
С.Цэлмэгсайхан (зөвшилцсөнөөр)

Монголын нутгийн удирдлагын
холбооны тэргүүн С.Батболд
(зөвшилцсөнөөр)

Хэвлэлийн хүрээлэнгийн Гүйцэтгэх
захирал М.Мөнхмандах
(зөвшилцсөнөөр)

Жендэрийн үндэсний шинжээчдийн
бүлгийн гишүүн В.Онон
(зөвшилцсөнөөр)

Удирдлагын академийн Улсын
салбарын удирдлагын тэнхимийн
дэд профессор Ч.Эрдэнэчимэг

Нарийн бичгийн дарга:

Удирдлагын академийн Төрийн
инноваци, хөгжлийн албаны дарга
П.Бямбасүрэн

Жендэрийн үндэсний хорооны
ТХБ-ын хэлтсийн дарга С.Батцэцэг

2.Холбогдох хууль тогтоомж болон “Жендэрийн эрх тэгш байдлыг хангах салбар дундын стратеги төлөвлөгөө /2022-2031/-ний хэрэгжилтийг зохион байгуулах салбар дундын багийн ажиллах журам”-ын хүрээнд ажиллахыг багийн гишүүдэд даалгасугай.

3.Багийн гишүүдийг мэдээллээр хангаж ажиллах, тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нарийн бичгийн дарга П.Бямбасүрэн, С.Батцэцэг нарт даалгасугай.

ЗАХИРАЛ



Д.СҮРЭНЧИМЭГ



МОНГОЛ УЛСЫН
БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН
САЙДЫН ТУШААЛ

2024 оны 02 сарын 14 өдөр

Дугаар 170

Улаанбаатар хот

Дэд ажлын хэсэг байгуулах тухай

Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.3.1 дэх заалт, Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 4.2.8 дахь заалт, Жендэрийн үндэсний хорооны 2023 оны 03 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Жендэрийн эрх тэгш байдлыг хангах салбар дундын стратеги төлөвлөгөө (2022-2031)-ний “Уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах, дасан зохицоход жендэрийн тэгш оролцоог хангана” зорилгын хэрэгжилтийг зохион байгуулах дэд ажлын хэсгийг хавсралтад заасан бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

2. Жендэрийн эрх тэгш байдлыг хангах салбар дундын стратеги төлөвлөгөөний холбогдох зорилтын хэрэгжилтийг хариуцан зохион байгуулж, Жендэрийн үндэсний хорооны хуралдаанд тайлагнаж ажиллахыг дэд ажлын хэсэг (С.Цогтгэрэл)-т даалгасугай.

Б.Бат-Эрдэнэ

Б.БАТ-ЭРДЭНЭ

152400221

Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын
2024 оны ... дугаар сарын ... өдрийн
... дугаар тушаалын хавсралт

ЖЕНДЭРИЙН ЭРХ ТЭГШ БАЙДЛЫГ ХАНГАХ САЛБАР ДУНДЫН СТРАТЕГИ
ТӨЛӨВЛӨГӨӨ (2022-2031)-НИЙ “УУР АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТИЙГ СААРУУЛАХ,
ДАСАН ЗОХИЦОХОД ЖЕНДЭРИЙН ТЭГШ ОРОЛЦООГ ХАНГАНА” ЗОРИЛГЫН
ХЭРЭГЖИЛТИЙГ ЗОХИОН БАЙГУУЛАХ ДЭД АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Ажлын хэсгийн ахлагч:	С.Цогтгэрэл	(Байгаль орчин, аялал жуулчлалын яамны Төрийн нарийн бичгийн дарга)
Гишүүд:	Ч.Энх-Амгалан	(Соёлын яамны Төрийн захиргааны удирдлагын газрын дарга)
	Н.Баярмаа	(Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Гэр бүлийн бодлогын хэрэгжилтийн зохицуулах газрын дарга)
	Л.Балчинлуvsан	(Эдийн засаг, хөгжлийн яамны Нэгдсэн бодлого, төлөвлөлтийн газрын дарга)
	Д.Баярболд	(Эрүүл мэндийн яамны Нийтийн эрүүл мэндийн газрын дарга)
	О.Номинчимэг	(Нийслэлийн Засаг даргын Нийгмийн салбар, ногоон хөгжил болон агаар, орчны бохирдлын асуудал хариуцсан нэгдүгээр орлогч)
	А.Бүрэнбаатар	(Монголын үндэсний олон нийтийн радио телевизийн ерөнхий захирал)
	Л.Цэлмэгсайхан	(Хараат бус судалгааны хүрээлэнгийн захирал)
	Ж.Чойханд	(Уур амьсгалын өөрчлөлтийн судалгаа, хамтын ажиллагааны төв ТӨААТҮГ-ын захирал)
Нарийн бичгийн дарга:	Д.Энхжаргал	(Жендэрийн үндэсний хорооны ажлын албаны орон нутгийн хөгжлийн бодлого зохицуулалт хариуцсан ахлах мэргэжилтэн)
	Т.Энхзаяа	(Байгаль орчин, аялал жуулчлалын яамны жендэрийн асуудал хариуцсан мэргэжилтэн)

БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ЯАМ



МОНГОЛ УЛСЫН
БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ
САЙДЫН ТУШААЛ

2024 оны 04 сарын 18 өдөр

Дугаар А/180

Улаанбаатар хот

Дэд ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2 дахь хэсэг, Монгол Улсын Ерөнхий сайдын 2023 оны "Ажлын хэсэг байгуулах тухай" 205 дугаар захирамжийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Жендэрийн эрх тэгш байдлыг хангах салбар дундын стратеги төлөвлөгөө (2022-2031)"-ний "Зорилго 1. Охид, хөвгүүд, эмэгтэй, эрэгтэй хүмүүст эрүүл, аюулгүй амьдрах, сурч боловсрох тэгш боломж бүрдүүлнэ"-ийн хэрэгжилтийг зохион байгуулах дэд ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Дэд ажлын
хэсгийн дарга:

Боловсрол, шинжлэх ухааны яамны Төрийн нарийн бичгийн дарга

Гишүүд:

Боловсрол, шинжлэх ухааны яамны Боловсролын нэгдсэн бодлого, төлөвлөлтийн газрын дарга

Боловсрол, шинжлэх ухааны яамны Төрийн захиргааны удирдлагын газрын дарга

Боловсролын ерөнхий газрын Суралцагчийн хөгжлийн газрын дарга

Боловсрол, шинжлэх ухааны яамны Ерөнхий боловсролын бодлогын удирдлага, зохицуулалтын газрын Суралцагчийн хөгжил, төлөвшил, хамгааллын бодлогын удирдлага, зохицуулалт хариуцсан шинжээч

Цахим хөгжил, харилцаа холбооны яамны Төрийн захиргааны удирдлагын газрын салбарын шагнал хариуцсан ахлах мэргэжилтэн (зөвшилцсөнөөр)

Эрүүл мэндийн яамны Нийтийн эрүүл мэндийн газрын нөхөн үржихүй, эрэгтэйчүүд, залуучуудын эрүүл мэндийн асуудал хариуцсан мэргэжилтэн (зөвшилцсөнөөр)

Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн захиргааны удирдлагын газрын Үндэсний хөтөлбөр, хүний эрх, жендэрийн асуудал хариуцсан мэргэжилтэн (зөвшилцсөнөөр)

Эдийн засаг, хөгжлийн яамны Нэгдсэн бодлого, төлөвлөлтийн газрын Хүний хөгжлийн бодлого, төлөвлөлт хариуцсан мэргэжилтэн (зөвшилцсөнөөр)

Байгаль орчин, аялал жуулчлалын яамны Төрийн захиргааны удирдлагын газрын Төрийн нарийн бичгийн даргын туслах бөгөөд жендэр, хүний эрх хариуцсан мэргэжилтэн (зөвшилцсөнөөр)

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Гэр бүлийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын жендэрийн асуудал хариуцсан мэргэжилтэн (зөвшилцсөнөөр)

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Төрийн захиргааны удирдлагын газрын жендэрийн асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн (зөвшилцсөнөөр)

Соёлын яамны Төрийн захиргааны удирдлагын газрын Хөгжлийн хөтөлбөрийн тайлан, хүний эрх, жендэрийн асуудал хариуцсан мэргэжилтэн (зөвшилцсөнөөр)

Боловсролын ерөнхий газрын Насан туршийн боловсролын хэлтсийн Залуучууд, насанд хүрэгчдийн гэр бүлийн боловсрол хариуцсан арга зүйч, мэргэжилтэн

Биеийн тамир, спортын улсын хорооны Бодлогын хэрэгжилтийн хэлтсийн Биеийн тамирын арга хэмжээ, арга зүйчийн үйл ажиллагааны бодлогын хэрэгжилт хариуцсан ахлах мэргэжилтэн (зөвшилцсөнөөр)

Үндэсний статистикийн хорооны Нийгмийн статистикийн хэлтсийн Цаг ашиглалтын судалгаа болон жендэр, хэвлэл, сонин сэтгүүлийн статистик хариуцсан статистикч (зөвшилцсөнөөр)

“Бүх нийт боловсролын төлөө” иргэний нийгмийн үндэсний эвслийн Ерөнхий зохицуулагч (зөвшилцсөнөөр)

Нарийн бичгийн дарга: Жендэрийн үндэсний хорооны Салбар дундын бодлого зохицуулалт, хууль тогтоомжийн асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн (зөвшилцсөнөөр)

Боловсрол, шинжлэх ухааны яамны Төрийн захиргааны удирдлагын газрын Жендэр, төрийн бус байгууллагын хамтын ажиллагаа хариуцсан мэргэжилтэн

2. Дэд ажлын хэсгийн үйл ажиллагааг баталсан төлөвлөгөөний дагуу хэрэгжүүлж, үндсэн ажлын хэсэгт тайлагнахыг Дэд ажлын хэсгийн дарга (Х.Батжаргал)-д үүрэг болгосугай.

3. Энэхүү тушаал баталсантай холбогдуулан Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2024 оны “Дэд ажлын хэсэг байгуулах тухай” А/74 дүгээр тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

САЙД



Л.ЭНХ-АМГАЛАН



МОНГОЛ УЛСЫН
ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН
САЙДЫН ТУШААЛ

2024 оны 05 сарын 17 өдөр

дугаар 1/АБС

Улаанбаатар хот

Дэд ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2 дахь хэсэг Монгол Улсын Ерөнхий сайдын 2023 оны 205 дугаар захирамжийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Жендэрийн эрх тэгш байдлыг хангах салбар дундын стратеги төлөвлөгөө /2020-2023/-ний Зорилго

2. “Эдийн засгийн хүрээнд жендэрийн тэгш боломж, тэгш оролцоог дэмжинэ” зорилгын хэрэгжилтийг зохион байгуулах Дэд ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Дэд ажлын хэсгийн ахлагч:

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн дарга

Гишүүд:

Хөдөлмөр нийгмийн хамгааллын яамны Хүн амын, бүлгүүдийн хөдөлмөр эрхлэлтийн бодлого, зохицуулалт хариуцсан ахлах шинжээч С.Үржинбадам (зөвшилцсөнөөр)

Хөдөлмөр нийгмийн хамгааллын яамны Хүн ам, хөдөлмөрийн судалгаа, цалин хөлсний статистик хариуцсан мэргэжилтэн Н.Баасанням (зөвшилцсөнөөр)

Соёлын яамны Тогтоол шийдвэрийн биелэлт төлөвлөгөө, тайлан хариуцсан ахлах мэргэжилтэн Х.Даваадолгор (зөвшилцсөнөөр)

Цахим хөгжил харилцаа, холбооны яамны Төрийн захиргааны удирдлагын газрын Салбарын шагнал хариуцсан ахлах мэргэжилтэн Б.Батцэцэг (зөвшилцсөнөөр)

151240334

Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын Төсвийн зарлагын хэлтсийн ахлах мэргэжилтэн В.Содномдаржаа (зөвшилцсөнөөр)

Хүнс хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Бодлого төлөвлөлтийн газрын ахлах мэргэжилтэн Ц.Амгалан (зөвшилцсөнөөр)

Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн захиргааны удирдлагын газрын мэргэжилтэн Б.Баясгалан (зөвшилцсөнөөр)

Эдийн, засаг, хөгжлийн яамны Нэгдсэн бодлого төлөвлөлтийн газрын Хүний хөгжлийн бодлого, төлөвлөлт хариуцсан мэргэжилтэн М.Нандинцэцэг (зөвшилцсөнөөр)

Боловсрол, шинжлэх ухааны яамны Төрийн бус байгууллагын хамтын ажиллагаа хариуцсан мэргэжилтэн Ч:Онончимэг (зөвшилцсөнөөр)

Жендэрийн үндэсний шинжээч Ш.Ариунаа (зөвшилцсөнөөр)

Жендэрийн үндэсний хорооны Ажлын албаны Нийгмийн түншлэл, хамтын ажиллагаа хариуцсан мэргэжилтэн

Нарийн бичгийн дарга:

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Гэр бүлийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын Жендэрийн асуудал хариуцсан мэргэжилтэн

2.Дэд ажлын хэсгийн үйл ажиллагааг баталсан төлөвлөгөөний дагуу хэрэгжүүлж үндсэн ажлын хэсэгт тайлагнахыг Дэд ажлын хэсгийн дарга (Б.Алимаа)-д үүрэг болгосугай.



Х.БУЛГАНТУЯА